



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.03.11 № 03/343

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240101134/01/01 дугаартай Барилга, гадна фасадны засвар (Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, 34 дүгээр сургууль)-ын ажлын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Зураг төсөл боловсруулах байгууллагын тусгай зөвшөөрөл ТШЗ-19.3 шаардлагад заасан зөвшөөрлийн доторх агуулга адил боловч заалтын дугаар өөр байгаа нь тендерт оролцоход харшлахгүй эсэх.	Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгт ТШЗ-19.3-т тусгай зөвшөөрлийн хамгийн бага заалтыг шаардсан. Иймд шаардсан тусгай зөвшөөрөл болон түүнээс дээш бол шаардлагад нийцнэ. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлнэ.
2	Зураг төсөл боловсруулахад зөвхөн засвар хийгдэх ажлуудтай холбоотой зураг төслийг боловсруулах эсэх.	Зураг, төсөв боловсруулах даалгаварт заасан хийгдэх ажлуудын дагуу зураг төслийг боловсруулан, төсвийг тооцож ирүүлнэ үү.

Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 4.6 дахь хэсэгт “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.” гэсний дагуу тендер ирүүлнэ үү.